



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар A/08

Залаа

Хурдан морины уралдаан, сунгаа зохион  
байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, 16.4.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум орон нутгийн хэмжээнд өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахыг 2024 оны 05 дугаар сарын 01 хүртэл хугацаанд хориглосугай.

2.Орон нутгийн иргэд болон уяачдыг мэдээллээр ханган хамтран ажиллахыг багийн Засаг дарга нар болон сумын “Залаажинстийн хурд” уяачдын холбооны тэргүүн (Л.Чинзориг)-д зөвлөсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбадорж), Хамтарсан багийн нарийн бичгийн дарга (Ш.Даваацэрэн) нарт даалгасугай.

ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ



842301151